



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЖАВХЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН  
НАМД

2024.08.06 № ГНАТ-2024/13-УТН-НА-06  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020609

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Жавхлант сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр ( *07* хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Жавхлант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН ИТХ-ЫН**  
**2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЖ БҮЙ**  
**МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ийг үндсэн чиглэл болгон Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Монгол Ардын намын хорооноос сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг сумынхаа иргэд, ААН, байгууллагуудаас дэвшүүлсэн саналуудад тулгуурлан, 2024-2028 онд Жавхлант сумын хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД**  
**Эрүүл биед- Саруул ухаан**

- 1.1 Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг чанартай зохион байгуулж, иргэдийг бүрэн тэгш хамруулж, хүртээмжийг сайжруулна.
- 1.2 Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийн шалтгааныг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд сумын эрүүл мэндийн төвийн үйлчилгээг чиглүүлнэ.
- 1.3 Сумын эрүүл мэндийн төвийн иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, дуудлагын автомашинаар бүрэн хангана.
- 1.4 Эмч, эмнэлгийн ажилтнуудыг дотоод, гадаадад давтан сургаж, мэдлэг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.5 Эрүүл мэндийн төвийн цэвэр, халуун хүйтэн ус, бохирын байгууламжийг чанарын шаардлага хангасан түвшинд тоноглож, ажиллуулна.
- 1.6 Иргэдэд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээнд орчин үеийн цахим технологийг нэвтрүүлж, түргэвчилсэн оношилгоо, гэрээр үзүүлэх тусламжийн хүрээг өргөжүүлнэ.
- 1.7 Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ**  
**Боловсролтой иргэн - Хөгжлийн хөдөлгүүр**

- 2.1 2-5 насны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулна.
- 2.2 Сургуулийн хичээлийн байрын урсгал засварыг хийж, дотуур байрны дулаан алдагдлыг бууруулах, шаардлага хангасан ундны цэвэр усаар хангах, ариун цэврийн болон угаалгын өрөөний галын ослын стандарт, шаардлагыг хангуулж, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 2.3 Англи хэлний сургалтын анги танхимыг шаардлагатай хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж, англи хэлний багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад шатлан хамруулна.

- 2.4 Суманд шилжин ирж ажиллах багшид олгох дэмжлэгийг бий болгох, багш нарын орон сууцаар хангах зэргээр тогтвор суурьшилтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5 Хүүхэд багачуудыг улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнүүдэд оролцоход нь дэмжлэг үзүүлдэг, амжилтыг үнэлж урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.
- 2.6 Ерөнхий боловсролын сургуулийн хамтын ажиллагаатай аймаг сумдтай багш, сурагч солилцооны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.7 Хүүхэд хамгаалах өдөр өнжүүлэх төвийг байгуулж, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР**

- 3.1 “Монгол соёл- Монгол ахуй” төслийг хэрэгжүүлж соёлыг дэлгэрүүлэхэд соёл, спортын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 3.2 Соёлын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурингийн соёлыг дэлгэрүүлнэ.
- 3.3 Соёлын бүтээлч үйлдвэрийн-III хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4 Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг дэлгэрүүлэн дэмжих, урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 3.5 Хүүхэд залуучуудын хөгжлийн төв буюу Спорт заалыг ашиглалтад оруулж шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслүүдээр хангах ажлыг зохион байгуулна.
- 3.6 Спорт заалны бүтэц орон тоо, шаардлагатай төсвийг холбогдох байгууллагад уламжлан, үйл ажиллагааг тогтворжуулна.
- 3.7 Нийтийн биеийн тамирын үндсэн төрлүүдээр сумын аварга шалгаруулах тэмцээнүүдийг календарчилсан төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулж аймаг, улсын тэмцээнүүдэд тамирчдыг оролцоход дэмжлэг үзүүлж ажиллана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН**

### **Эрүүл аюулгүй орчин- Аз жаргалтай амьдрал**

- 4.1 Жил бүр ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 4.2 Сумын төвийн үерийн хамгаалалтын далан, шуудуу, ус зайлуулах хоолой, гарцыг зураг, төсвийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 4.3 Гудамжны авто замуудыг сайжруулсан болон хатуу хучилттай болгоно.
- 4.4 Шинэ суурьшлын бүсүүдэд шинээр гудамж үүсгэх, дэд бүтэц, цахилгааны шугам татах ажлыг хийж хэрэгжүүлнэ.
- 4.5 Алслагдсан газруудад үүрэн холбооны станц шинээр суурилуулж, хүрээг тэлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 4.6 Сумын төвлөрсөн хогийн цэгийг жилд хоёроос доошгүй удаа түрж дарах, тэгшлэх, аюулгүй хог хаягдлыг булшлах тусгай зориулалтын байгууламжийг шинээр байгуулна.

- 4.7 Сумын төвийн бүх гудамж, сумаас орж, гарах чиглэл, төрийн байгууллага, ААН-үүдийг бүрэн камержуулж, аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 5.1 Орон нутгийн нөөц боломж, давуу байдалд тулгуурласан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.2 Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.3 Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 5.4 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 5.5 Иргэдэд нийтийн эзэмшлийн талбайд төвлөрсөн үйлчилгээ эрхлэх боломжийг олгоно.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛ

### 6.1 Аялал жуулчлал

- 6.1.1 Аймаг, сумын аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг сайжруулж, хөгжүүлнэ.
- 6.1.2 Сум, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.1.3 Монголын түүх, шашин, соёлын хадгалагдаж үлдсэн өв, тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлал болон томоохон голуудын сав дагуух спорт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.1.4 Жуулчдад зориулсан сумын онцлог бүхий урлаг, соёлын хөтөлбөр, эвент арга хэмжээнүүдийг бий болгож, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 6.1.5 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтална.
- 6.1.6 Аялал, амралт, жуулчлалын чиглэлд дэд бүтцийг сайжруулж, дөрвөн улирлын аяллыг хөгжүүлнэ.
- 6.1.7 Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.

### 6.2 Газар тариалан

- 6.2.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 6.2.2 Стратегийн хүнсний зориулалттай болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 6.2.3 Тариалангийн үйлдвэрлэлд тэг болон цомхотгосон, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгальд ээлтэй бордооны хэрэглээг төлөвшүүлж, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулна.
- 6.2.4 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын

- хэрэгцээнд жилийн турш тогтвортой нийлүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулна.
- 6.2.5 Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 6.2.6 Сумын газар тариалангийн эргэлтийн талбайн 40 хувиас доошгүйд уринш бэлтгэж, газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана.
- 6.2.7 Тариалангийн хөрсний үржил, шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордооны хангамжийг 70 хувьд хүргэнэ.
- 6.2.8 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

### **6.3. Мал аж ахуй**

- 6.3.1 Сумын хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн малчин, мал бүхий иргэдэд түгээн дэлгэрүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 6.3.2 Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, халдварт өвчлөлгүй тайван байдлыг баталгаажуулна.
- 6.3.3 Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 6.3.4 Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлнэ.
- 6.3.5 Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 6.3.6 Хоршоололд суурилсан хамтын ажиллагааны хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамруулах, малчид болон хоршоологчдод хуульд нийцүүлэн газар олголтыг дэмжиж ажиллана.
- 6.3.7 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех, мал нядалгааны цэг, сумандаа хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 6.3.8 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.
- 6.3.9 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах бодлого баримталж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 6.3.10 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийг нэмэгдүүлнэ.
- 6.3.11 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.
- 6.3.12 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.

### **ДОЛДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН**

- 7.1 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан ойн зурвас байгуулах, хөрс хамгаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 7.2 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомсдол, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 7.3 Сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнын тархцын судалгааг явуулж, бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тархалтыг бууруулна.
- 7.4 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 7.5 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 7.6 Голын эх, ус, намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажих, эзэмших, бохирдуулахаас сэргийлэн шингээх чадварыг хэвээр нь хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна.
- 7.7 Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### **НАЙМДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА**

- 8.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 8.2 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 8.3 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.
- 8.4 Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.
- 8.5 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 8.6 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 8.7 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээнд дотоод хяналтыг чанартай гүйцэтгэж, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 8.8 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 8.9 Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлэн, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 9.1 Сумын иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, дэд бүтэц бүхий ногоон байгууламж, хүүхдийн болон биеийн тамирын талбайг орчинг хөгжүүлнэ.
- 9.2 Төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 9.3 Уст цэгүүдийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар ард иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангана.
- 9.4 Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн стандартыг хангуулж, сумын соёлыг нэмэгдүүлнэ.
- 9.5 Хүн амын суурьшлийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын халаалтын нам даралтын зуухыг бүрэн зогсоож, халаалтын төвлөрсөн системд холбуулснаар агаарын бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл амьдрах орчныг дээшлүүлнэ.
- 9.6 Шаардлагатай тохиолдолд сумын эдийн засаг, тохижилт, нийгмийн өмнө тулгарч байгаа бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан ард иргэдээр эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана.
- 9.7 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.
- 9.8 Сумын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн амар тайван орчныг бэхжүүлнэ.
- 9.9 Спортын ордны үйл ажиллагааг түшиглэн хүүхэд хөгжлийн төвийг байгуулан, тогтвортой ажиллуулна.
- 9.10 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих замаар нэмүү өртөг шингэсэн хүнсний ногооны боловсруулах цех байгуулна.
- 9.11 Шарын голын тосгон, гурван замын уулзвар, сумын төвийн шинэ суурьшлын бүсүүдэд цахилгааны эх үүсвэр буюу 0.4квт-ийн шугамыг татах ажлыг хийж гүйцэтгэнэ.

**Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван сум болно.**

*Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын МАН-ын Хорооноос Жавхлант сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ*



хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Жавхлант сайхан нутгаа **"ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ"**.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

У-Т 40065 9055436